

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2020 оны 01 дүгээр сары 07-ны өдөр

Авлигатай тэмцэх, ажлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх жүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хийгдэх ажил	Хугацаа	Биелэлт
1.	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтны ХАСУМ-ыг хянасан байдлыг үндэслэн томилгоо хийх.	Томилогдохоор нэр дэвшиж буй хүний ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлэн хянуулна.	Тухай бүр	Тус компанийн эрх бүхий албан тушаалтнаар томилогдхоор нэр дэвшсэн хүмүүсийн ХАСУМ-ыг тухай бүр АТГ-т хүргүүлэн хянуулж санал авч ажиллаж байна. 2020 онд эрх бүхий албан тушаалтнаар томилогдхоор нэр дэвшсэн 3 хүний ХАСУМ-ыг хүргүүлж санал авсан байна.
		АТГ-аас ХАСУМ-ыг хянаж, дэмжсэн нэр дэвшигчийг эрх бүхий албан тушаалтнаар томилно.	Тухай бүр	АТГ-аас ХАСУМ-ыг хянаж дэмжсэн 3 эрх бүхий албан тушаалтныг томилсон.
2.	Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 6.1.8, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4.1, 24.1.5-д заасныг хэрэгжүүлэх.	Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ыг хуульд заасан хугацаанд гаргуулан цахим системд бүртгэх.	I улирал	Компанийн эрх бүхий тушаалтанууд болон ТУЗ-ийн гишүүн нийт 13 хүнээс ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд гаргуулан авлигатай тэмцэх газрын цахим системд бүртгэсэн. Мөн 2020 онд хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон нэг эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг цахим системд бүртгэж баталгаажуулсан.
		Холбогдох тайлан мэдээг гаргаж АТГ,ЭТТ ХК-д хүргүүлэх.	I улирал	Тус компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийн тайланг нэгтгэн АТГ, ЭТТ ХК-д хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.
3.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг компанийн эрх бүхий тушаалтан болон нийт ажилтануудад сурталчлах.	Авлигатай тэмцэх газраас бэлтгэдэг сургалт, сурталчилгааны ном, материалаар эрх бүхий албан тушаалтнуудыг хангах.	I улирал	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс уридчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн гарын авлагыг компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ажлын хэрэгцээнд зориулан тараасан.

4.	Компанийн ёс зүйн зарчмыг тогтоомж, дагаж мөрдөх.	Ёс зүйн дүрмийг шинээр томилогдсон ажилтан бүрт тухай бүр нь танилцуулж байх.	Тухай бүр	Шинээр томилогдсон ажилтануудад тухай бүрт танилцуулан ажиллаж байна.
		Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, ёс зүйн зөрчлийн талаар өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх.	Тухай бүр	Ёс зүйн дүрмийн зөрчилтэй холбогдолтой өргөдөл гомдолыг хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ёс зүйн хорооны дарга бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. Одоогоор ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ирээгүй байна.
5.	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, хариуцлага хүлээлгэх дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	Дотоод аудитын ажилтнуудыг томилж ажилд нь оруулах.	I улирал	Компанийн Хяналт шалгалт үнэлгээ дотоод аудитын албыг байгуулж дарга, ажилтнууд томилогдон ажиллаж байна. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/66 дугаар тушаалын дагуу ёс зүйн хороог байгуулж дарга гишүүдийг томилон авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шалгах тогтолцоог бий болгон ажиллаж байна.
		Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шалгах, шаардлагатай бол АТГ-т шилжүүлж шалгуулах.	Тухай бүр	Одоогоор авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ирээгүй байна.
6		Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар, шийдвэр, үйл ажиллагааг өөрчлөх буюу хүчингүй болгох.	Тухай бүр	"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хэмжээнд дагаж мөрдүүлэхээр Гүйцэтгэх захирлын баталсан нийт 13 журам, хэм хэмжээ тогтоосон 2 тушаалын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааг ХШҮДАА-наас 2020 оны 05 дугаар сард зохион байгуулсан. Мөн компанийн дотоод үйл ажиллагаанд даган мөрдөж байгаа журам, заавар, шийдвэрт авилга, ашиг сонирхол, ёс

				зүйн зөрчил гарах нөхцөл боломж бүрдүүлсэн заалт, үг үсэг, утга найруулга байхгүй байна.
7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдалыг хангах.	Тендерийн урилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар мэдээллэж байх.	Тухай бүр	Худалдан авалт хангамжийн хэлтсээс тендерийн холбогдолтой материалыг Хамтын ажиллагааны хэлтэсээр дамжуулан сонин, сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэж байна.
		Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоонд, ТББ-ын төлөөллийг оролцуулах.	Тухай бүр	Үнэлгээний хороонд ТББ-ийн төлөөлөл бүхий хоёр зөвлөхтэй гэрээ байгуулан ажиллаж байна.
		Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсанд мэдээллэх.	Тухай бүр	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тендер зарлагдснаас эхэлж тендерийн үр дүн зэргийг цахим хуудсанд байршуулж байна.
8.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах.	Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд мэдээлнэ.	Хуульд заасан хугацаанд	Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.4 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолыг үндэслэн "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/10 тушаалаар Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолд нийцүүлэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг эрхлэн хөтлөх ажлыг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх шийдвэр гарсан. /Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл нь нууцын зэрэглэлтэй явагдаж байгаагаас хамаарч зарим нууцад хамаарах мэдээлэлийг байршуулах боломжгүй байна. /
		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх /Шилэн дансанд байршуулах/.	Хуульд заасан хугацаанд	Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.4 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолыг үндэслэн "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/10 тушаалаар Шилэн дансны тухай хууль болон Засгийн

				газрын 2016 оны 29 дүгээр тогтоолд нийцүүлэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг эрхлэн хөтлөх ажлыг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх шийдвэр гарсан. /Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл нь нууцын зэрэглэлтэй явагдаж байгаагаас хамаарч зарим нууцад хамаарах мэдээлэлийг байршуулах боломжгүй байна. /
9.	Компанийн хүний нөөцийн ил тод байдлыг хангах.	Компанийн сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулна.	Тухай бүр	2020 оны 02-р сарын 04, 2020 оны 04-р сарын 06, 2020 оны 05-р сарын 06-ны өдрүүдэд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэстэй хамтран дараах 9 суваг дээр нээлттэй ажлын байрны идэвхжүүлэлт хийж, инженер, техникийн ажилтнуудын сул орон тоог нөхөн бүрдүүлэлт хийх зорилгоор нээлттэй сонгон шалгаруулалт зарласан болно. Үүнд 1. "Тавантолгой төмөр зам" ХХК албан ёсны сайт www.ttz.mn 2. "Тавантолгой төмөр зам" ХХК-ны албан ёсны Фэйсбүүк пэйж 3. Зарын сайт www.zarmedee.mn 4. Зар мэдээ сонин 5. Нийслэлийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн сайт 6. Нийслэлийн 9 дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс 7. Дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний фэйсбүүк хуудас 8. ШУТИС-ийн албан ёсны сайт www.must.edu.mn 9. Эрдэнэс-Таван толгой ХК www.ett.mn Нийт
		"Тавантолгой төмөр зам" ХХК-д ажил гориллогчийг сонгон шалгаруулалт явуулах талаар нээлттэй зарлаж байх. Гурван	Тухай бүр	Нийт 19 төрлийн ажлын байрыг 9 суваг дээр нээлттэй гадаад болон дотооддоо ил зарлаж сонгон шалгаруулалт хийж ажилласан. 1. Геодезийн инженер 2. Гүүр хоолойн инженер

		шатны ярилцлага хийж байх.		3.Тоо хэмжээний инженер 4.Барилгын инженер 5.Замын инженер 6.Материалын инженер 7.Хийцийн инженер 8.Дохиолол холбооны инженер 9.Эрчим хүчний инженер 10.Төмөр замын Замын инженер 11.Хиймэл байгууламж, гүүр хоолойн инженер 12.Зүтгүүрийн инженер 13.Вагоны инженер 14.Тоо хэмжээний инженер 15.Хөрс болон цемент бетоны лаборант 16.Хүнд машин механизмын оператор 17.Лаборант 18.Лабораторийн инженер, Лабораторийн туслах ажилтан нийт
10.	Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах.	Авлигатай тэмцэх газраас санал зөвлөмж ирүүлбэл биелэлтийг зохион байгуулна.	Тухай бүр	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн санал зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
		Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалт, хурал зөвлөгөөнд холбогдох ажилтныг оролцуулж байх.	Тухай бүр	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2 удаагийн сургалт, хурал зөвлөгөөнд тус компанийн ЭБАТ В.Лхагвадорж тогтмол оролцож байна.

Нэгтгэсэн:


Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн



В.Лхагвадорж

Хянасан:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга



И.Идэш

Танилцсан:

Захиргаа удирдлагын газрын



Ц.Болд